



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/110/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.11</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6.ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.24 № 2/29
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020210

d:\2025 он\бичиг хэрэг\тоот\2. а4-албан тоот.docx

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд нийт 40 ажил төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь 91 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮГЭХ
АУДИТОР
Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66761877.97	47500099.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1748500.00	5594100.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1748500.00	5594100.00
3121	Төгрөг	1748500.00	5594100.00
31211	Төрийн сангийн харилцах	1748500.00	5594100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	65013377.97	41905999.82
351	Түүхий эд материал	27586971.62	23075916.62
35110	Тусгай зориулалттай материал	26951521.62	22556461.62
35130	Эм боох материал	635450.00	519455.00
354	Хангамжийн материал	37426406.35	18830083.20
35410	Бичиг хэргийн материал	2631560.00	931450.00
35420	Аж ахуйн материал	21921491.00	12613927.00
35430	Сэлбэг хэрэгсэл	150000.00	150000.00
35440	Түлш, шатах тослох материал	411000.00	0.00
35460	Хүнсний материал	3327129.55	1143933.00
35470	Бусад хангамжийн материал	8985225.80	3990773.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1394188404.50	1513431521.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1394188404.50	1513431521.03
392	Биет хөрөнгө	999423671.28	1118488787.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	1134018211.54	1207211843.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-257430192.70	-297833627.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92833333.00	179476332.84
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77388889.12	-87779340.23
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171449615.90	177458615.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-103864413.87	-113908188.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99506754.00	119329254.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64485895.47	-70251249.42
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4715148.00	4715148.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	70000.00	70000.00
393	Биет бус хөрөнгө	394764733.22	394942733.18
39301	Програм хангамж	6417692.31	6310000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4203359.09	-3917666.82
39303	Бусад биет бус хөрөнгө	392550400.00	392550400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1460950282.47	1560931620.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	382500.00	659100.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	382500.00	659100.00
413	Өглөг	382500.00	659100.00
4136	Бусад өглөг	382500.00	659100.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	382500.00	659100.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1460567782.47	1560272520.85
51	Засгийн газрын хувь оролцоо	1460567782.47	1560272520.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	221624669.45	221624669.45
51101	Өмч: - төрийн	221624669.45	221624669.45
512	Хуримтлагдсан үр дүн	807913002.55	910237069.93
51210	Өмнөх үеийн үр дүн	859619809.00	810532330.75
51220	Тайлант үеийн үр дүн	-51706806.45	99704739.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431030110.47	428410781.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1460950282.47	1560931620.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1132363772.42	1611334261.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16397872.42	212809761.34
120	Нийтлэг татварын бус орлого	16397872.42	212809761.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16327872.42	212739761.34
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175000.00	130000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16152872.42	212609761.34
120009	Бусад орлого	70000.00	70000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1115965900.00	1398524500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1110465900.00	1398524500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1110465900.00	1398524500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5500000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5500000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1184070578.87	1511629522.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1184070578.87	1511629522.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1047841309.00	1358368342.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727926899.87	985210563.39
210101	Үндсэн цалин	444962809.78	487277000.00
210102	Нэмэгдэл	223793092.62	403304523.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34177482.68	68355000.00
210104	Урамшуулал	24993514.79	26274040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14416809.86	22103544.27
210201	Тэтгэврийн даатгал		1813216.08
210202	Тэтгэмжийн даатгал		213319.54
210203	ҮОМШӨ-ний даатгал		96970.69
210204	Ажилгүйдлийн даатгал		106659.77
210205	Эрүүл мэндийн даатгал	14416809.86	19873378.19

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108268295.20	133509026.18
210301	Гэрэл, цахилгаан	14119875.40	16528333.78
210302	Түлш, халаалт	85496631.80	106186096.40
210303	Цэвэр, бохир ус	8651788.00	10794596.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29223395.20	57952523.60
210401	Бичиг хэрэг	5762780.00	6270270.00
210402	Тээвэр, шатахуун	20274000.00	23283300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1584715.20	2256920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600000.00	1380000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1001900.00	1796845.00
210408	Бараа материал акталсны зардал		22965188.60
2105	Нормативт зардал	52659934.00	46016889.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1204500.00	1615995.00
210502	Хоол, хүнс	50931066.00	41463493.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	524368.00	2937400.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13079610.00	12426120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1118400.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	261300.00	
210604	Урсгал засвар	11699910.00	12426120.00
2107	Томилолт, зочны зардал	1312000.00	1231200.00
210702	Дотоод албан томилолт	1312000.00	1231200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11764045.00	10915069.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4049200.00	3821900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	300000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321952.00	295064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5466500.00	4987400.00
210807	Газрын төлбөр	1549393.00	1433705.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89190319.87	89003406.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6457794.00	4873310.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1100000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81632525.87	84130096.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136229269.87	153261180.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	136077945.00	153222093.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	130687945.00	145877093.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5390000.00	7345000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	151324.87	39087.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	151324.87	39087.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-51706806.45	99704739.18
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-51706806.45	99704739.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1123760575.13</u>	<u>1416164862.84</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7936000.00	17679450.00
120	Нийтлэг татварын бус орлого	7936000.00	17679450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2620000.00	7360450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2620000.00	7360450.00
120009	Бусад орлого	5316000.00	10319000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1115824575.13	1398485412.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1110324575.13	1398485412.84
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1110324575.13	1398485412.84
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5500000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5500000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1122012075.13</u>	<u>1412319262.84</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1122012075.13	1412319262.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	985924130.13	1259097169.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	733242899.87	995529563.39
210101	Үндсэн цалин	450267419.24	487277000.00
210102	Нэмэгдэл	223804483.16	413623523.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34177482.68	68355000.00
210104	Урамшуулал	24993514.79	26274040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14416809.86	22103544.27
210201	Тэтгэврийн даатгал	0.00	1813216.08
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	213319.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	96970.69
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	106659.77
210205	Эрүүл мэндийн даатгал	14416809.86	19873378.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108268295.20	133509026.18
210301	Гэрэл, цахилгаан	14119875.40	16528333.78
210302	Түлш, халаалт	85496631.80	106186096.40
210303	Цэвэр, бохир ус	8651788.00	10794596.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27946065.20	32833500.00
210401	Бичиг хэрэг	4798750.00	5425280.00
210402	Тээвэр, шатахуун	19984000.00	22199300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1584715.20	2256920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600000.00	1380000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	978600.00	1572000.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2105	Нормативт зардал	55043700.00	40780297.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1204500.00	1500000.00
210502	Хоол, хүнс	53839200.00	39280297.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24354015.00	14786120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12392805.00	4700000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	261300.00	0.00
210604	Урсгал засвар	11699910.00	10086120.00
2107	Томилолт, зочны зардал	1312000.00	1231200.00
210702	Дотоод албан томилолт	1312000.00	1231200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19256545.00	17823919.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11541700.00	10730750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	300000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321952.00	295064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5466500.00	4987400.00
210807	Газрын төлбөр	1549393.00	1433705.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2083800.00	500000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	983800.00	500000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1100000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136087945.00	153222093.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	136077945.00	153222093.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	130687945.00	145877093.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5390000.00	7345000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10000.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1748500.00	3845600.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1748500.00	3845600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1748500.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1748500.00	5594100.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	859,619,809.00	1,512,274,588.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,619,328.20	2,619,328.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	862,239,137.20	1,514,893,917.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-2,619,329.00	0.00	-2,619,329.00
C07	Тайлант үеийн үр дүн			-51,706,806.45	-51,706,806.45
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	428,410,781.47	810,532,330.75	1,460,567,781.67
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	425,791,452.47	758,825,524.30	1,460,567,781.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,619,328.20	2,619,328.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,624,669.45	428,410,781.47	813,151,658.95	1,463,187,109.87
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-2,619,329.00	0.00	-2,619,329.00
D08	Тайлант үеийн үр дүн			99,704,739.18	99,704,739.18
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	425,791,452.47	912,856,398.13	1,560,272,520.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,399,024,500.00	1,398,685,412.84	339,087.16	100.0

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,399,024,500.00	1,398,685,412.84	339,087.16	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,252,487,300.00	1,252,148,319.84	338,980.16	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	995,533,800.00	995,529,563.39	4,236.61	100.0
210101	Үндсэн цалин	485,871,200.00	487,277,000.00	(1,405,800.00)	100.3
210102	Нэмэгдэл	394,789,000.00	413,623,523.39	(18,834,523.39)	104.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,332,000.00	68,355,000.00	6,977,000.00	90.7
210104	Урамшуулал	39,541,600.00	26,274,040.00	13,267,560.00	66.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,112,900.00	22,103,544.27	9,355.73	100.0
210201	Тэтгэврийн даатгал	1,810,700.00	1,813,216.08	(2,516.08)	100.1
210202	Тэтгэмжийн даатгал	213,100.00	213,319.54	(219.54)	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	106,600.00	96,970.69	9,629.31	91.0
210204	Ажилгүйдлийн даатгал	96,900.00	106,659.77	(9,759.77)	110.1
210205	Эрүүл мэндийн даатгал	19,885,600.00	19,873,378.19	12,221.81	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,514,300.00	133,509,026.18	5,273.82	100.0
210301	Гэрэл, цахилгаан	16,764,600.00	16,528,333.78	236,266.22	98.6
210302	Түлш, халаалт	106,246,100.00	106,186,096.40	60,003.60	99.9
210303	Цэвэр, бохир ус	10,503,600.00	10,794,596.00	(290,996.00)	102.8
2104	Хангамж, бараа материалын зардал	32,833,500.00	32,833,500.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	5,481,500.00	5,425,280.00	56,220.00	99.0
210402	Тээвэр, шатахуун	22,200,000.00	22,199,300.00	700.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,256,920.00	(56,920.00)	102.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,380,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,572,000.00	1,572,000.00	-	100.0

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2105	Нормативт зардал	40,780,300.00	40,780,297.00	3.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210502	Хоол, хүнс	39,280,300.00	39,280,297.00	3.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,086,200.00	14,786,120.00	300,080.00	98.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,700,000.00	4,700,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,386,200.00	10,086,120.00	300,080.00	97.1
2107	Томилолт, зочны зардал	1,231,200.00	1,231,200.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,231,200.00	1,231,200.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,895,100.00	10,875,069.00	20,031.00	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,781,900.00	3,781,900.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,000.00	295,064.00	19,936.00	93.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,987,400.00	4,987,400.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,433,800.00	1,433,705.00	95.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,537,200.00	146,537,093.00	107.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,537,200.00	146,537,093.00	107.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	145,877,200.00	145,877,093.00	107.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	660,000.00	660,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,399,024,500.00	1,398,885,412.84	139,087.16	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,398,524,500.00	1,398,685,412.84	(160,912.84)	100.0

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,398,524,500.00	1,398,685,412.84	(160,912.84)	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	200,000.00	300,000.00	40.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	200,000.00	300,000.00	40.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35.00	35.00	-	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	35.00	35.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба тайлант онд шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2024 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,981.3 мянган төгрөг буюу 6,8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,761.8	47,500.0	19,261.7
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,748.5	5,594.1	(3,845.6)
БАРАА МАТЕРИАЛ	65,013.3	41,905.9	23,107.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,394,188.4	1,513,431.5	(119,243.1)
Хуримтлагдсан элэгдэл	(507,372.7)	(573,690.0)	(66,317.3)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,460,950.2	1,560,931.6	(99,981.3)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	382.5	659.1	(276.6)
Засгийн газрын хувь оролцоо	1,460,567.7	1,560,272.5	(99,704.7)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,460,950.2	1,560,931.6	(99,981.3)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,594.1 төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 3,845.6 мянган төгрөгөөр өссөн нь ялтны нэрийн дансны үлдэгдэл өмнөх оноос 276.6 мянгаар, байгууллагын ахмадын сангийн дансны үлдэгдэл өмнөх оноос 3,569.0 мянгаар өссөнтэй холбоотой байна.

Тайлан онд тус байгууллагад авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,905.9 мянган төгрөг болж 23.107.3 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон 4,994.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 4,395.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал акталж данснаас хасаж, 9,307.5 мянган төгрөгийн аж ахуйн материал зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,513,431.5 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 99,981.3 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 461-р тогтоолоор 74,900.0 мянган төгрөгийн барилга, 788-р тогтоолоор 4,075.0 мянган төгрөгийн автомашин, 2,250.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 798-р тогтоолоор 6,667.9 мянган төгрөгийн автомашин, Н-1/11 дугаар тогтоолоор 75,900.0 мянган төгрөгийн автомашин орлогод авч, 588-р тогтоолоор хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл 23,473.8 мянган төгрөгөөр балансын үнэ нэмэгдэж дахин капиталжуулсан бол 461-р тогтоолоор 1,706.3 мянган төгрөгийн барилга байгууламж шилжүүлж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,560.2 мянган төгрөг болж 99,704.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 151,411.5 мянган төгрөгийн өсөлт голлох нөлөөг үзүүлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,398,524.5 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 500.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,399,024.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,398,524.5 мянга, өөрийн үндсэн үйл ажиллагаанаас 500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,398,563.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянга, оны эхний үлдэгдэл 5,594.1 мянга, урсгал үйл ажиллагаанд 1,398,685.4 мянган төгрөгийг зарцуулж, 3,607.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,398,685.4 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 99.9 хувийг зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл		1,399,024.50	1,398,685.41	339.09	100.0
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,251,452.90	1,251,113.81	339.09	100.0

3	80220 Холбооны суваг ашигласны хөлс	1,034.40	1,034.40	-	100.0
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	146,537.20	146,537.20	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 53,839.2 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол хүнс нийлүүлэх тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан бөгөөд Софтвишн ХХК шалгарч 49,580.8 мянган төгрөгийн гэрээг 2024 оны 03-р сарын 27-нд байгуулан 2024.12.31-ныг хүртэлх хугацаанд хоол хүнс нийлүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв болох 1,375,589.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 20,633.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 14,443.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш дүнтэй орлогын 1,336,939.7 мянган төгрөгийн 15 гүйлгээ, зарлагын 262,801.8 мянган төгрөгийн 16 гүйлгээг мэдээлсэн бөгөөд 57,298.5 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээг аудитын явцад нөхөн мэдээлсэн болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэсэн бөгөөд тус аудитаар 311,389.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 18,750.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлснээс биелэлт 100 хувь байна.

Хүнснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Албан шаардлага	3	311,389.50	1	311,389.50	100
Зөвлөмж	1	18,750.00	1	18,750.00	100
Нийт дүн	4	330,139.50	4	330,139.50	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тус байгууллага нь үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу байгууллагын дагаж мөрдөх хуулийн хүрээнд болон санхүүгийн зарчмын хувьд хууль, дүрэм журмыг зөрчөөгүй 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөх санал хүргүүлээ.

6. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ					1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ					1			

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----